



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/388

Хэрлэн сум

Газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Арван гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар өмчлөх хүсэлт гаргаж материал бүрдүүлэлтийг бүрэн хангасан нэр бүхий 28 иргэнд 1,9 га газрыг өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөх иргэдийн нэрс, газрын хэмжээ байршлыг 1 дүгээр, байршлын зургийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Өмчилж авсан газраа кадастрын болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч (М.Шүрэнцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

